



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/1690

Булган сум

“Булган аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулж, батлуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 онд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах тухай аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Булган аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулж, батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд:
- Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
  - Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
  - Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга)
  - Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
  - Ч.Цогбуян (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
  - Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
  - М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
  - Э.Мөнх-Очир (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч)
  - М.Бадам (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч)
- Нарийн бичгийн дарга: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

0325010947

2. Үндсэн чиглэлийг аргачлалын дагуу чанартай боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 2025 оны 12 дугаар сард батлуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР